



18 01 23 56

**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/06

Бор-Өндөр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий нэгж
талбарыг нэгтгэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Орон сууцны зориулалттай эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 2 нэгж талбарын газрын хэмжээг нэгтгэх хүсэлт гаргасан Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн газрыг нэгдүгээр хавсралтад заасны дагуу нэгтгэсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн газрын хэмжээгээр олгож газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д даалгасугай.

3. Газар эзэмших гэрээний нөхцөл, зориулалтын дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн Захиралд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЧИНБАТ




Сумын Засаг даргын 2023 оны
01 сарын 23 өдрийн
06 тоот захирамжийн
Нэгдүгээр хэвсрэлт.

Нэгтгэгдэж байгаа нэгж талбарын мэдээлэл

Д/д	Газар эзэмшигч хуулийн этгээдийн нэр	регистр	нэгтгэгдэж буй нэгж талбарын				Нэгтгэгдсэн нэгж талбарын газрын		
			байршил	нэгж талбарын дугаар	хэмжээ	хэмжээ	зориулалт	эзэмших хугацаа /жил/	
1	Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Бор- Өндөр Уулын баяжуулах үйлдвэр	2550466	2-р баг, Их тойруу-3 гудамж, 313 тоот	2322003156	540	1080	2203: 4 ба түүнээс доош давхрын нийтийн орон сууц	38	
			2-р баг, Их тойруу-3 гудамж, 313а тоот	2322003563	540				

Хэнтий аймаг Бор-Өндөр сумын 2-р баг Нийтийн орон сууц
баригдах талбайн дэвсгэр зураг



№	X	Y
1	5123340.25	378833.48
2	5123323.39	378858.63
3	5123352.7	378878.88
4	5123369.26	378853.62

Масштаб 1: 1000
Үеийн өндөр-1.0м

Боловсруулсан:
Маркшейдер

[Signature]
Ц.Пүрэвсүрэн
2022. 6/30.